

АРИЛЖААНЫ БАНКНЫ ӨРТӨГ ТООЦОХ АРГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Abstract

In order to manage adequately any business and organizations in nowadays, providing information about cost and expense, however its analysis is more crucial for managers and owners. In management science, the cost accounting has been developed for detailed cost information that management needs. Compared to approaches on traditional costing system, it is more important how commercial banks can efficiently use the modern cost accounting trends for estimating their costs of products and services. This research aims to develop use of activity based costing system and to enhance their effectiveness of cost management on Mongolian commercial banks.

Keywords: *Cost accounting, traditional costing system, activity based costing system.*

Хураангуй

Аливаа байгууллагыг удирдахад үйл ажиллагааны үр дүнг тодорхойлж, түүнд дүн шинжилгээ хийх, хяналт тавихад зардал, өртгийн мэдээлэл туйлын хэрэгцээтэй байдаг. Өртгийн мэдээллийг хангахад нягтлан бодох бүртгэлийн нэг төрөл болох өртгийн бүртгэл нь амин чухалд тооцогддог. Өртгийн бүртгэл нь өртгийг дансанд хуримтлуулах төдий зүйл биш харин үйл явцыг хянах, зардлыг бүртгэх, хуваарилахтай холбогдсон мэдээллээр удирдлагыг хангах, бизнесийн төлөвлөгөө боловсруулах, шинжилгээ хийх зэргийг хамарсан бүхэл бүтэн цогц ойлголт юм. Өртөг тооцоололтын орчин үеийн чиг хандлагуудыг тодорхойлж, өртгийн мэдээллийн ач холбогдлыг монголын арилжааны банкны системийн хүрээнд тодорхойлох нь чухал ач холбогдолтой билээ.

Түлхүүр үгс: *Зардал, өртгийн бүртгэл, уламжлалт болон үйлдэлд суурилсан өртөг тооцох арга*

Оршил

Арилжааны банкны ашигт ажиллагааны түвшинд олон хүчин зүйлс нөлөөлж байгаа боловч тэдгээр хүчин зүйлүүдээс үйл ажиллагааны бус зардал жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байна. Мөн сүүлийн жилүүдэд арилжааны банкны зардлын бүртгэлийн тогтолцоонд ахиц гарч байгаа боловч зардал, өртөгийн мэдээллийн системийг удирдлагын шийдвэр гаргалтанд оновчтой хэрэглэх шаардлага хэрэгцээ байсаар л байна. Магадгүй арилжааны банкны өртөгийн системийг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх нэг хувилбар байж болох юм. Нөгөө талаар дэлхийн бусад орнуудад өргөн ашиглагдаж байгаа арга туршлагыг нэвтрүүлэх замаар арилжааны банкуудын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжийг судлах гэсэн үндэслэл дээр энэхүү сэдвийг сонгож байна. Үүний тулд арилжааны банкуудын үйл ажиллагаанд тохирсон өртгийн системийг нэвтрүүлэх арга замыг тодорхойлох судалгаа, шинжилгээг хийнэ. Арилжааны банкны бүтээгдэхүүний өртгийг тооцох өнөөгийн байдалд үнэлэлт өгч, сайжруулах боломжит хувилбарыг тодорхойлох явдал нь судалгааны зорилго юм.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг тооцох арга зүй

Өргөн утгаараа зардал нь орлогоосоо хасагдаж байгаа зарцуулсан зүйлсийн өртөг юм. Иймд бүтээгдэхүүн үйлчилгээнд шингээж байгаа зардлын дүнг өртөг болно.

Өртөг юу гэдэг талаар гэдгийг дараах эрдэмтэд тодорхойлсон байдаг. Үүнд:

- Өртөг нь үнэ цэн бий болгохтой холбоотой ашигласан нөөцүүдийн үнэ цэн юм (Catherine and Joe 2003:xiv).

- Санхүүгийн бүртгэлийн үүднээс, өртөгийн шинж чанар нь тодорхой бүтээгдэхүүн үйлчилгээг олж авахын тулд зарцуулсан нөөцийн үнэ цэн юм (Ray 1988:29).

• Солилцох үнэ, найдвартай орлого олохын тулд өмнө золиосолж байгаа зардал юм. Зардлыг үйл ажиллагааны тодорхой объекттой холбон тодорхой хугацаагаар зааглан хуримтлуулсныг өртөг (Асри and Хаммер 2000:17) гэж үзсэн байна.

Энэ бүгдээс нэгтгэн авч үзвэл зардлыг үйл ажиллагааны тодорхой объекттой холбон тодорхой хугацаагаар зааглан хуримтлуулсныг *өртөг* гэнэ (Edward, David, and Gary 2009:66). *Өөрөөр хэлбэл*, өртөг гэдэг нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхийн тулд зарцуулж байгаа нөөцүүдийн үнэ цэн юм.

Өртөг тооцоололтуудыг авч үзэхийн тулд дараах үндсэн ойлголтуудыг зайлшгүй авч үзэх шаардлагатай. *Үүнд*: Өртгийн объект, зардлын төв, өртөг тооцох систем, өртөг тооцох арга, зардал чиглүүлэгч зэрэг болно.

1.1 Өртгийн объект

Өртгийн объектын тухай ойлголт өртгийн бүртгэлийн хамгийн өргөн хүрээтэй ойлголтуудын нэг юм. Өртгийн объектын тухай ойлголт нь өртөгийн тодорхойлолтын цөм хэсэг. Өртгийн объектын сонголт нь **“ЮУНЫ ӨРТӨГ ВЭ?”** гэсэн өртгийн үндсэн асуултын хариулт болно. Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг тодорхойлохын тулд бололцоотой объектоор нь зардлыг хуримтлуулан бүртгэдэг. Зардлыг хуримтлуулан өртгийг тодорхойлох боломжийг бүрдүүлж байгаа аливаа нэгж, үйл ажиллагаа буюу тохиолдлыг *өртгийн объект* гэнэ (Michael, David, and Igor 2000:17). Өртгийг тодорхойлох аргагүй, зардлыг төсөвлөх, түүний гүйцэтгэлийг хянах, тайлагнах, хэрэгцээнээс хамаарч өртгийн объект өөр өөр байж болно (Michael, David, and Igor 2000:8).

1.2 Зардлын төв

Байгууллага нь бүтээгдэхүүнтэй холбоотой гарах зардлуудыг хянах, хариуцлага тооцох механизмыг бий болох үүднээс зардлын төвүүдийг тодорхойлж тэдгээрт гарсан зардлаа хуримтлуулан бүртгэдэг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотойгоор гарсан зардлыг тооцож хуримтлуулах, хяналт тавих боломжтой бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд өөрийн бие даасан үүрэг гүйцэтгэдэг нэгж хэлтэс *зардлын төв* болно (Edward, Kung, and Thomas 2002:66).

Зардлын төв нь дараах шинж чанарыг агуулсан байна. Үүнд:

- Бие даасан үүрэг гүйцэтгэдэг нэгж байна.
- Зардал байгаа эсэх нь шууд тодорхойлогдох болон хянагдах боломжтой байна.
- Нэг хэлтэст хамаарах боловч өөр төрлийн ажил үүргийг гүйцэтгэж байгаа үед тэдгээртэй холбогдон гарсан зардлыг нэг ижил суурийг ашиглан хуваарийг боломжтой байна.

1.3 Өртөг тооцох систем

Олон судлаач өртгийн суурийг тодорхойлох, өртөг тооцох арга, зардлыг хуримтлуулан бүртгэх аргуудын боломжит хувилбаруудыг нэгтгэн өртгийн системийг бүрдүүлж байна гэж үздэг.

Америкийн эрдэмтэн Милтон Ф.Асри, Лоренс Х.Хаммер, Уиллям К.Картер нар өртгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох гурван нөхцөл, зардлыг үйлдвэрлэлийн өртөгт шингээх гурван нөхцлийг тодорхойлж “Өртгийн матрицан хэлбэр” гэж нэрлэсэн байна. Энэхүү матрицаар өртгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох сууриудыг гүйцэтгэлийн, урьдчилсан тодорхойлсон хэмжээгээр, гүйцэтгэлийн ба урьдчилан тодорхойлсон хэмжээний холимог гэсэн гурван нөхцөл, зардлыг үйлдвэрлэлийн өртөгт шингээх аргуудаар үндсэн, хувьсах, бүрэн шингээх гэсэн гурван нөхцөлтэй байж болохыг санал болгож (Асри and Хаммер 2000:44), эрдэмтэд өртөг тооцох аргуудыг авч үзэн мөн чанарыг (Асри and Хаммер 2000:55) тодорхойлсон байна. Эдгээр аргаар өртөг тооцоход зардлыг аль өртөгт бүрэн шингэж байгаагаас хамаарч бүрэн зардлаар өртөг тооцох, хувьсах зардлаар өртөг тооцох хувилбарууд байж болох (Асри and Хаммер 2000:528–562) талаар дурьдсан байдаг.

Английн эрдэмтэн Колин Друри (Colin 1994) гүйцэтгэлийн ба стандарт өртгийн суурь бүрэн ба хувьсах зардал, үйл ажиллагаанд суурилсан өртөг тооцох аргуудыг зэрэгцүүлэн судалж, давуу болон сул талуудыг тодорхойлж, уламжлалт болон үйлдэлд суурилсан өртгийн системийн хөгжилд чухал нэмэр оруулсан байна.

Америкийн эрдэмтэн Жеймс Р.Мартин өртгийн бүртгэлийн систем нь 5 бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг гэж тодорхойлжээ. Хэдийгээр бүх хувилбар тохиромжтой бус байж болох

боловч боломжит хувилбаруудаас янз бүрээр сонгон авч зардлын бүртгэлийн системийг зохиож, боловсруулж болно. Төрөл анги бүрээс аль нэгийг нь сонгон авч өртгийн тодорхой нэг зардлын бүртгэлийн системийг гарган авах боломжит хувилбараар онол аргазүйн шинэлэг бүтцийг (James R 2005:chap. II) тодорхойлсон байна.

Эндээс өртгийн өгөгдлийг хэмжих суурь, өртөг тооцох аргууд, зардлыг хуримтлуулах аргуудын нэгдлийг өртгийн систем гэж тодорхойлж болно. Өртгийн систем нь дараах гурван хувилбараар хөгжиж ирсэн (Тунгалаг 2004:28).

Үүнд:

- Гүйцэтгэлийн зардлаар өртөг тооцох систем
- Холимог зардлаар өртөг тооцох систем
- Стандарт зардлаар өртөг тооцох систем зэрэг болно.

Мөн эдгээр системүүд дангаараа өртгийн системийг бүрдүүлэхгүй, бусад бүрэлдэхүүнтэй нэгтгэснээр иж бүрэн өртгийн систем болно гэдгийг Жеймс Р.Мартин (James R 2005:Chapter II) тодорхойлж гаргасан байна. Дээрх системүүдээс арилжааны банкны үйл ажиллагааны онцлогоос хамаарч гүйцэтгэлийн зардлаар өртөг тооцох систем нь илүү тохирч байна. Учир нь арилжааны банкны хувьд тодорхой норм, стандарт, технологийн горим шаардлагагүй зөвхөн гүйцэтгэлээр өртөгийг тооцож, өртгийн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргалтанд ашиглана.

1.4 Өртөг тооцох арга зүй

Өртөг тооцох гэдэг нь тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарсан зардлыг нэр төрлөөр нь хуримтлуулах, шууд ба шууд бусаар нь ангилах, шууд зардлыг ногдуулах, шууд бус зардлуудыг хуваарилах цогц үйл ажиллагаа юм. Өртөг тооцох аргууд нь шууд бус зардлыг өртөгт хэрхэн шингээж байгаагаас хамаарч гурван түвшинд авч үздэг.

Үүнд:

• *Үйлдвэрлэлийн хэмжээнд* – Шууд бус зардлаа хуваарилахдаа зөвхөн нэг нэгдмэл зардлын чиглүүлэгчийг ашигладаг. Ихэнх тохиодолд энэ түвшинд шууд хөдөлмөр цаг байдаг.

• *Хэсэг нэгжийн түвшинд* – Шууд бус зардлыг хуваарилахдаа хэсэг нэгж бүр өөрийн онцлогт тохирсон нэмэгдэл зардлын чиглүүлэгчийг ашигладаг. Энэ түвшинд машин цаг, хөдөлмөр цаг, шууд материалын зардал зэрэг нь зардлын чиглүүлэгч болно. Арилжааны банкинд энэ түвшин илүү тохирно.

• *Үйлдэл, үйл ажиллагаанд* – Шууд бус зардлыг үйлдэл, үйл ажиллагаа, үйл явцад зардал чиглүүлэгчээр, үйлдлийн өртгийн эцсийн бүтээгдэхүүнд үйлдэл чиглүүлэгчээр дамжуулан хуваарилана.

Арилжааны банкны салбарт шууд бус зардлыг өртгийн объект буюу бүтээгдэхүүнд хуваарилахдаа зардал чиглүүлэгчийг ашиглан уламжлалт болон үйлдэлд суурилсан өртөг тооцох аргуудаар бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг тооцно. Энэхүү 2 аргаас арилжааны банк нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон аргыг сонгоно.

1.4.1 Уламжлалт өртөг тооцох арга

Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд оруулсан хувь нэмрээр шууд бус зардлыг хурваарилах аргыг “Уламжлалт өртөг тооцох арга” гэнэ”. Шууд бус зардлыг бүтээгдэхүүнд нэг буюу түүнээс дээш шатлалаар хуваарилж болох ба энэ нь байгууллагын бүтэц ба өртгийн объектын түвшин хир зэрэг нарийн түвэгтэй байхаас шалтгаална.

Эхний шаг нь бүх шууд бус зардлыг үндсэн үйл ажиллагааны нэгжүүд (эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг нэгжүүд буюу шууд зардлын нэгжид хуваарилна. Хоёр дахь шатаар үндсэн үйл ажиллагааны нэгжид хуримтлагдсан зардлыг бүтээгдэхүүнд хуваарилна. Ингэхдээ ихэвчлэн шууд хөдөлмөрийн цаг, шууд хөдөлмөрийн зардал, эсвэл бүтээгдэхүүнд ногдох санхүүжилтийн хувь хэмжээ зэрэг нэг суурийг сонгон авч ашиглана.

Түүхийн явцад бусад салбартай харьцуулахад банкны байгууллагад удирдлагын бүртгэл их хожуу нэвтэрсэн байдаг. Энэ нь хязгаарлагдсан хөгжлийн бас нэгэн шалтгаан юм. *Жишээ нь:* 1980-аад он хүртэл банкны салбарын өрсөлдөөний нөхцөл нь удирдлагын бүртгэл, удирдлагын төлөвлөлт болон хяналтын тогтолцооны хөгжлийн хөшүүрэг болж хараахан чадаагүй байсан. *Нөгөөтэйгүүр*, банкны бизнесийн үндэс нь болсон дотоодын нөхцөл байдал болон үйл ажиллагааг компаниуд гүйцэтгэж байгаа нь бусад салбараас ялгаатай байдаг. Ийм

загварын шилжилт нь санхүүгийн салбар болон үйлдвэрүүдийн хөгжилд саад болж байв. Түүнчлэн тус систем нь яагаад банк санхүүгийн байгууллагууд бусад салбараасаа хожимдож бүрэн зардлын бүртгэлийн системийг ашиглах болсон шалтгааныг тайлбарлаж, (Carenys and Sales 2008:38) мөн банкинд зардлуудыг шингээхээс илүүтэйгээр ашгийн шинжилгээ хийх хэрэгтэй (Mecimore C and Cornick M 1982:13) гэж үзсэн байна.

Үүнтэй адил АНУ-ын банкуудад судалгаа хийсний эцэст банкууд бүтэн зардалдаа бага ач холбогдол өгч, харин зардлын удирдлага болон шууд зардалдаа илүү анхаарч байгааг шүүмжилжээ. Гэхдээ шууд бус зардлын хэмжээ ихэсвэл шууд зардлын систем нь төлөвлөлт, хяналтад ач холбогдол муутай болно. Иймд энэ системийг шууд бус зардлын түвшин өндөртэй, олон төрлийн бүтээгдэхүүнтэй компанийн хувьд хэрэглэх нь хязгаарлагдмал болж байна. Эцэст нь банк санхүүгийн байгууллага (шууд бус тогтмол зардал өндөртэй)-д энэ аргыг хэрэглэх нь ач холбогдол багатай болохыг тогтоосон (Carenys and Sales 2008:39) байна.

1.4.2 Үйлдэлд суурилсан өртөг тооцох арга (ABC)

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын үе шат, үйл явцаар дамжуулан шууд зардлыг эцсийн бүтээгдэхүүнд хуваарилах аргыг “Үйлдэлд суурилсан өртөг тооцох арга (ABC)” гэнэ.

ABC арга нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нарийсч, зардлыг оновчтой хуваарилах шаардлагын үүднээс гарч иржээ. 1980-аад оны үед байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгараад байсан гол асуудал нь үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын хэмжээ өсөх тусам түүнийг удирдах үр ашигтай арга хангалттай түвшинд байж чадахгүй болсон байна. ABC арга нь үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын бүртгэлд үндсэн өөрчлөлтийг хийжээ. 1989 оноос Германд “Үйл ажиллагааны зардлын бүртгэл” нэртэйгээр хөгжүүлсэн бол 1990-ээд оны АНУ-ын Hewlett-Packard, John Deere, Siemens, GM болон томоохон компаниудад амжилттай хөгжиж, зардлыг хэмжих талд илүү анхаарч ажилласан байна. Японы үйлдвэрүүдэд зардлын удирдлага, хямдралт, бизнесийн эрүүл орчин бүрдүүлж, үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулахад (Тунгалаг 2004:36–37) өргөнөөр ашиглаж ирсэн байна.

1980-аад оноос эхлэн банк санхүүгийн салбарт ABC аргачлалыг нэвтрүүлэх талаарх судалгаанууд хийгдэж эхэлжээ. 1988 онд Гарднер, Ламмэрс нарын АНУ-ын арилжааны банк, хадгаламж зээлийн хоршооноос нягтлан бодох бүртгэл, удирдлагын хяналтын түвшинг тодорхойлох зорилгоор судалгаа явуулсан байна. Судалгааны үр дүнд шууд бус хувиргалтын зардлыг зорилготойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээ болон харилцагчдад хуваарилах нь удирдлагыг шийдвэр гаргахад бодитой мэдээллээр хангах ач холбогдолтойг (Gadner M and Lammers L 1988:38) нотолсон байна.

1997 онд Иннес Ж, Митшэл Ф нар Их Британийн 31 томоохон банк санхүүгийн байгууллагууд (БСБ)-ын хүрээнд судалгаа явуулжээ. Судалгааны үр дүнд банк санхүүгийн байгууллагын удирдлагын бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулахад ABC аргачлал нь чухал ач холбогдолтойг (Innes and Mitchell Jan 1997) харуулсан байна.

2006 онд Иорди Каринис, Хавиар Сэлис нар Испаний 26 хадгаламжийн банк, АНУ-ын 40 арилжааны банкуудад явуулжээ. Үүнд:

- Зөвхөн шууд зардлыг бус нийт зардлыг бүтээгдэхүүн, үйлчилгээ болон харилцагчдад хуваарилах нь зүйтэй юм.
- Удирдлагын шийдвэр гаргалтад шууд бус хувиргалтын зардлын мэдээлэл чухал нөлөөтэйг баталсан.
- ABC аргачлалыг тухайн үед зардлыг хянах, бууруулахаар ашиглаж байсан ба үүнийг өргөн хүрээнд сайжруулан ашиглах нь ач холбогдолтойг (Carenys and Sales 2008:49–50) харуулсан.

1.5 Зардал чиглүүлэгч

Шууд бус зардал бүтээгдэхүүнд чиглэсэн эсвэл бүтээгдэхүүний нийлүүлэлтээс шалтгаалж буй түвшин буюу, өөрөөр хэлбэл тодорхой хэмжээний зардал гарахад хүргэж байгаа шалтгаан ба үр дагавар нь бүтээгдэхүүнд шууд бус зардлыг хуваарилах үндэслэл болно. Зардал чиглүүлэгч гэдэг нь хуваарилагдаж буй шууд бус зардалтай хүчтэй хамаарал бүхий үйл ажиллагаа, үйлдэл буюу хүчин зүйл (Edward, Kung, and Thomas 2002:66) юм.

Зардал чиглүүлэгчийг зөв ойлгож ашигласнаар зардлын хуваарилалт нь илүү оновчтой болно. *Жишээ нь*, түрээс болон цэвэрлэгээний зардлыг хэд хэдэн бүтээгдэхүүнд хуваарилахад

чиглүүлэгч нь тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглаж буй талбайн хэмжээ байна. Ялангуяа материаллаг зардлын хувьд чиглүүлэгч болон хуваарилалтын горимыг зөв сонгохгүй бол өртгийн хэмжээ ихээхэн хэлбэлзэхэд хүрнэ. Зардал тус бүрээр чиглүүлэгч буюу хуваарилалтын суурийг тодорхойлохдоо тэрхүү зардал чиглүүлэгчийн хэмжээг тооцох аргыг тусгана. Каплан, Атинсон (Kaplan & Athinson, 1998), Күүпэр (Cooper R, 1989) нар тухайн үйлдэл хэдэн удаа, хугацаагаар, ашиглагдах нөөцийг бүртгэх зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан зардлын чиглүүлэгчийн ангилалыг тодорхойлж гаргаж ирсэн байна. Үүнд: Гүйлгээний, хугацааны, эрс хүчний гэх мэт. Мөн Датар (Datar et al. 1993), Ванг (Wang et al. 2010) нарын хийсэн судалгаагаар хамгийн бага квадратын арга буюу олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээг ашиглан хамгийн их хамаарал бүхий зардал чиглүүлэгчийг тодорхойлж, ашиглах нь үр дүнтэй болохыг харуулсан байна.

Арилжааны банкууд нь бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал, шат дамжлага, нэгж бүрийн нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ зэргээс хамаарч зардлыг хуримтлуулан бүртгэх, хуваарилах харилцан адилгүй аргыг ашиглаж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааны онцлог байдал, шаардлагад тохирсон өртөг тооцох аргаа өөрсдөө тогтооно. Нэг төрлийн бүтээгдэхүүн нийлүүлдэг байгууллагын хувьд гарсан нийт зардлыг түүний тоо хэмжээнд харьцуулах замаар нэгжийн өртөг тооцож бодохоос зардлыг хуримтлуулан бүртгэх нь ч хялбар байх талтай. Гэвч ихэнх байгууллагууд хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн нийлүүлдэг, эсвэл нэг бүтээгдэхүүнийг олон хэлтэс, тасаг дамжуулан нийлүүлдэг. Ийм нөхцөлд зардлыг хэрхэн хуримтлуулах, хуримтлуулсан зардлыг бүтээгдэхүүн бүрт яаж хуваарилах талаар тохирсон арга зүйг сонгох нь чухал.

Арилжааны банкны үйлчилгээний өртөг тооцоололтын өнөөгийн байдал

Арилжааны банкны системд сүүлийн жилүүдэд өрсөлдөөн ихсэж, технологийн дэвшил, хүүгийн түвшний өөрчлөлт, санхүүгийн зах зээлийн өргөжилт, улмаар нөөцийн өртөг ихсэж ашгийг бууруулах болсон. Мөн салбарын үйл ажиллагаа өргөжин тэлж, харилцагчийн тоо нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагааны зардлууд ч нэмэгдсээр байна.

Арилжааны банкууд нь бүтээгдэхүүнийг хүргэх суваг буюу салбар, тооцооны төвүүд болон бүтээгдэхүүний багцын өртгийг тооцож байгаа боловч үйл ажиллагааны нэг л түвшинд үндэслэсэн нь өртгийн мэдээллийн үнэн зөв байдлыг алдагдуулж байна. Арилжааны банкны хувьд маркетингийн зардал, шинэ техник, технологийн ашиглалт зэргээс хамаарч шууд бус зардлын хувь хэмжээ их байгаа ба түүнийг бүтээгдэхүүн үйлчилгээнд үнэн зөв хуваарилах зайлшгүй шаардлагатай байна (Туяа and Мөнхсүрэн 2011:110).

Арилжааны банкны зардлын бүртгэл болон өртөг тооцох системд үнэлгээ өгч бүтээгдэхүүн өртгийг тооцох аргуудыг тодорхойлох зорилгоор судалгааг явуулсан. Судалгаанд нийт 13 арилжааны банкны санхүү бүртгэл, төлөвлөлт, удирдлагын бүртгэл зэрэг газар, хэлтэс, албадын нийт 47 ажилтнуудаас анкет болон ярилцлагын аргаар судалгааг авсан.

Судалгааны үр дүнд арилжааны банкуудад дараах нийтлэг асуудлууд ажиглагдлаа.

- Өртөг тооцох системийн ялгаатай байдал нь арилжааны банкны активын хэмжээнээс хамаарч байна. Том болон дунд ангилалд багтах банкуудад өртгийн мэдээллийн хэрэгцээ харьцангуй өндөр байдаг, үүнтэй холбоотойгоор үйлчилгээний өртөг тооцох төдийгүй түүнийг сайжруулах оролдлого хийдэг байна.

- Арилжааны банкуудын үйл ажиллагааг өргөжихийн хэрээр бүтээгдэхүүний өртгийн мэдээллийн хэрэгцээ их байдаг нь дундаас дээш ангилалд байгаа банкуудад илүү байна.

- Системийн хэмжээнд бүтээгдэхүүний өртгийг бүрэн тооцож чадахгүй байна.

- Арилжааны банкуудын одоогийн ашиглаж буй уламжлалт өртгийн системийг сайжруулах шаардлагатай байна.

- Арилжааны банкны салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг тооцох системийг зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх асуудал төдийлөн судлагдаагүй байсаар байна. Мөн удирдлагын бүртгэлийн тогтолцооны томоохон хэсэг болох зардлын бүртгэлийн систем, түүний гүйцэтгэх үүрэг, зориулалтын талаарх нэгдсэн ойлголтогүй байсаар байна.

Дээрх судалгааны дүгнэлтүүдийг нэгтгээд дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Өртөгийн талаарх нэгдсэн ойлголтогүй байна.

- Арилжааны банкны хувьд НББ-ийн систем нь өртгийн тооцоололтыг дэмжих мэдээллийг гаргаж чадахгүй байна.

- Өртөг тооцох тодорхой аргачлал байхгүй байна. Зарим нэг банкуудад өртөг тооцох оролдлогуудыг хийсэн боловч иж бүрэн байдлаар хэрэгжүүлсэн байдал дутмаг байна.

Судалгаанд хамрагдсан арилжааны банкнаас дундаж ангилалд байгаа банкны 1 салбар дээр бүтээгдэхүүний өртөг тооцох арга хувилбаруудаас “Уламжлалт өртөг тооцох арга”-аар тооцоололтыг хийлээ. Тухайн салбарын хувьд байгуулагдаад 10 гаруй жил үйл ажиллагааг явуулж байна. Салбар нь нийт 10 ажилтантай. Тус салбарт 20XX оны эцсийн байдлаар нийт 22 төрлийн зардлууд гарсан байна. Хамгийн өндөр зардал нь цалин хөлсний зардал 49.91 хувийг эзэлж байна. Эдгээр зардлуудыг Хүснэгт 2.1-т харууллаа.

Хүснэгт 2.2 20XX оны эцсийн байдлаар гарсан зардлууд /хувиар/

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	ДҮН
1	Цалин хөлс нэмэгдэл	49.91
2	ҮХ урсгал засвар борлуулалтын үйл ажиллагааны зардал	17.40
3	Элэгдэл хорогдол	5.98
4	Нийгмийн даатгалын шимтгэл	4.91
...
22	Даатгалын зардал	0.04
НИЙТ		100.00


Тус арилжааны банк нь “Банкны тухай хууль”-ийн 6.1-6.2 зүйлд заасны дагуу дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг. Бүтээгдэхүүнд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тохиолдолд бүтээгдэхүүн гэж авч үзнэ. Эдгээр шалгуур үзүүлэлтэд өөрийн гэсэн өртөгтэй, тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, байршил зэрэг нөхцлүүд хамаарагдана (Саранчимэг et al. 2007:53). Дээрх шалгууруудыг хангасан гэж үзээд арилжааны банкны хувьд харилцах, хадгаламж, зээл, төлбөр тооцоо, бусад үйлчилгээ зэрэг бүтээгдэхүүнүүд өртгийн объект болно. Салбарын бүтэц зохион байгуулалт болон зардлын төвүүд, бүтээгдэхүүний объектыг Дүрслэл 2.1-д харууллаа.

Дүрслэл 2.1 Салбарын бүтэц зохион байгуулалт болон зардлын төвүүд



Банк нь бүтээгдэхүүнтэй холбоотой гарах зардлуудыг хянах, хариуцлага тооцох механизмыг бий болгох үүднээс “Зардлын төв”-үүдийг тодорхойлж тэдгээрт гарсан зардлаа хуримтлуулан бүртгэнэ. Дүрслэл 2.2-оор бүтээгдэхүүний өртөг тооцох аргачлалыг харууллаа.

Дүрслэл 2.2 Бүтээгдэхүүний өртөг тооцох арга болон хувилбар



Банкны бүтээгдэхүүний зардлыг нийлүүлж байгаа бүтээгдэхүүндээ шууд эсвэл тодорхой зардал чиглүүлэгчийг ашиглан хуваарилалт хийж ногдуулдаг эсэхээс хамааруулан *шууд* болон *шууд бус* гэж ангилна. Шууд ба шууд бус зардлын ялгаа нь өртгийг зардлын объектод ногдуулах зарчимд үндэслэнэ.

Шууд бус зардлыг тодорхой зардал чиглүүлэгчийг ашиглан бүтээгдэхүүн эсвэл зардлын төвд хуваарилна. *Жишээ нь:* Ажилчдын тоо өсөхөд цалин хөлс, НШД, ЭМД, боловсон хүчний бусад зардал, харилцаа холбоо, ариун цэвэр, зочин төлөөлөгч зэргийн зардлууд өсч, шууд хамааралтай байна. Зардал чиглүүлэгчийг зөв тодорхойлсноор холбогдох шууд бус зардлуудыг илүү оновчтой хуваарилах боломжтой болдог. Хүснэгт 2.3-д шууд бус зардлуудыг хуваарилахад ашиглан зардал чиглүүлэгчийн тоон утгууд болон тэдгээрийн нийт дүнд эзлэх хувийн жинг харууллаа.

Хүснэгт 2.3 Шууд бус зардлыг зардлын төвүүдэд хуваарилахад ашиглах зардал чиглүүлэгч

№	Зардал чиглүүлэгч	Зардлын төвүүд					Нийт
		Харилцах	Хадгаламж	Төлбөр тооцоо	Бусад үйлчилгээ	Зээл	
1	Ажилчдын тоо	1.25	1.25	1.25	1.25	5	10
	Нийт дүнд эзлэх хувь	12.5%	12.5%	12.5%	12.5%	50.0%	100%
2	Гүйлгээний тоо	4,837	3,521	8,668	119	1,693	18,838
	Нийт дүнд эзлэх хувь	26%	19%	46%	1%	9%	100%
3	Талбайн хэмжээ	36.4	36.4	36.4	36.4	84.2	230
	Нийт дүнд эзлэх хувь	16%	16%	16%	16%	37%	100%
4	Харилцагчийн тоо	1698	1914	2003	59	859	6,533
	Нийт дүнд эзлэх хувь	26%	29%	31%	1%	13%	100%

Зардал чиглүүлэгчийг тодорхойлсны дараа зардал тус бүрийг зардлын төвүүдэд хуваарилах боломжтой болно. Хүснэгт 2.4-д шууд болон шууд бус зардлуудыг зардлын төвүүдэд хуваарилаж, нийт гүйлгээ болон харилцагчийн нэгжийн өртгийг тооцож харууллаа.

Хүснэгт 2.4 Нийт гүйлгээ болон харилцагчийн нэгжийн өртгийн тооцоололт

№	Зардлын төрөл	Зардлын төвүүд					Нийт дүн /мян.төг/
		Зээл	Харилцах	Хадгаламж	Төлбөр тооцоо	Бусад үйлчилгээ	
1	Шууд зардал	6,669.10					96,669.10
2	Шууд бус зардал	49,062.86	48,455.32	48,971.78	49,395.39	43,991.63	239,876.97
	НИЙТ ЗАРДАЛ	145,731.96	48,455.32	48,971.78	49,395.39	43,991.63	336,546.07

3	Нийт гүйлгээ /тоо/ Нэгж өртөг	1,693.00 86.08	4,837.00 10.02	3,521.00 13.91	8,668.00 5.70	119.00 369.68	18,838.00
4	Нийт харилцагч /тоо/ Нэгж өртөг	859.00 169.65	1,698.00 28.54	1,914.00 25.59	2,003.00 24.66	59.00 745.62	6,533.00

Жишээ нь, тухайн банкны хувьд жилдээ зээлийн нэг гүйлгээ хийхэд 86,08.0 мян.төг, 1 харилцагчид зээлийн үйлчилгээ үзүүлэхэд 169,650.0 мян.төг тус тус шууд бус зардлыг зарцуулсан байна.

Дүгнэлт

Өртгийг хэрхэн тооцох нь арилжааны банкинд бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байгаа ба өртгийн мэдээллийн хэрэгцээ жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байна. Банкны салбарт шууд бус зардлын хувь хэмжээ их байгаа ба түүнийг бүтээгдэхүүн үйлчилгээнд үнэн зөв хуваарилах шаардлагатай байна. Иймд өртгийг илүү нарийн тодорхойлох арга аргачлал боловсронгуй болгох шаардлагатай байгааг нь дээрх судалгаагаар нотлогдож байна.

Өртөг тооцох ямар аргыг ашиглах нь арилжааны банкинд тохиромжтой вэ? Түүнийг хэрхэн нэвтрүүлэх вэ? гэдгийг цаашид нарийвчлан судлах хэрэгцээ өндөр байна. Арилжааны банкны хувьд бүтээгдэхүүн үйлчилгээний тохирсон өртгийн аргыг ашигласнаар дараах боломжуудыг олгоно.

Үүнд:

- Зардал бүрийг хянах боломжтой болно.
- Үнэн зөв, бодитой өртөг тооцогдох ба түүнийг ашиглан удирдлага зөв шийдвэр гаргах боломж нэмэгдэнэ.
- Үйлчилгээнд үнэ цэн нэмэхгүй үйлдлийг тодорхойлж, зардлыг бууруулах, үйл ажиллагаа зардал хоорондын хамаарлыг тодорхойлж гаргаж ирснээр үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- Гүйцэтгэлийг бодитоор үнэлэх үнэлэмжийг бий болгох зэрэг болно.

Ном зүй

1. Carenys, Jordi, and Xavier Sales 2008 Costing the Banking Service: A Management Accounting Approach. Journal of Money, Investment and Banking (6): 34–53.
2. Catherine, Stenzel, and Stenzel Joe 2003 Essentials of Cost Management. New Jersey, USA: John Wiley & Sons, Inc.
3. Colin, Drury 1994 Costing an Introduction. 3rd edition. United Kingdom: Chapman & Hall.
4. Datar, Srikant M., Sunder Kekre, Tridas Mukhopadhyay, and Kannan Srinivasan 1993 Simultaneous Estimation of Cost Drivers. The Accounting Review 68(3): 602–614.
5. Edward, J. Blocher, E. Stout David, and Cokins Gary 2009 Cost Management: A Strategic Emphasis. 5th edition. McGraw-Hill/Irwin.
http://takkagri.weebly.com/uploads/3/0/3/1/30319257/7.cost_mgt_by_blocher.pdf.
6. Edward, J. Blocher, H. Chen Kung, and W. Lin Thomas 2002 Cost Management: A Strategic Emphasis. 2nd edition. New York: McGraw-Hill/Irwin.
7. Gardner M, and Lammers L 1988 Cost Accounting in Large Banks 29(10): 34–39.
8. Innes, John, and Falconer Mitchell 1997 The Application of Activity-Based Costing in
9. the United Kingdom's Largest Financial Institutions. Service Industries Journal 17(1): 190–203.
10. James R, Martin 2005 Management Accounting: Concepts, Techniques & Controversial Issues. 1st edition. <http://maaw.info/MAAWTextbookMain.htm>.
11. Mecimore C, and Cornick M 1982 Banks Should Use Management Accounting Models: 13–18.
12. Michael, H. Granof, E. Plant David, and Vaysman Igor 2000 Using Activity-Based Costing to
13. Manage More Effectively. <http://costkiller.net/tribune/Tribu-PDF/Using-Activity-Based-Costing-to-Manage-More-Effectively.pdf>.

14. Ray, H.Garrison 1988 *Managerial Accounting: Concepts for Planning, Control, Decision Making*. 5th edition. Plano, Texas USA: Business Publications, INC.
15. Wang, Pingxin, Fei Du, Dinghua Lei, and Thomas W.Lin 2010 The Choice of Cost Drivers in Activity-Based Costing: Application at a Chinese Oil Well Cementing Company. *International Journal of Management* 27(2): 367–380.
16. Асри, Милтон Ф., and Лоренс Х. Хаммер 2000 Зардлын нягтлан бодох бүртгэл: Төлөвлөлт ба Хяналт. 10th edition. “Өнгөт хэвлэл” ХК.
17. Саранчимэг, Аюуш, Ланган Отгонтуяа, Бямбадаш Мөнхбаяр, and Жигдэн Жаргалсүрэн 2007 Төсвийн байгууллагын төсөв, санхүү, бүтээгдэхүүний өртөг тооцоололт. 1st edition. Улаанбаатар.
18. Тунгалаг, Нацагдорж 2004 Зардал-Удирдлагын бүртгэл: Шинжилгээ- загварчлал. 1st edition. Улаанбаатар: “Хөх судар принтинг” ХХК.
19. Туяа, Тэгшээ, and Мянганбаяр Мөнхсүрэн 2011 Арилжааны банкны үйлчилгээний өртөг тооцох боломж. СЭЗДС, Багш нарын ЭШХ-ын эмхэтгэл 2: 103–111.